

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**



**БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2021 он

## АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН.....	3-8
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, түүний хэрэгжилт	
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН .....	9-10
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН .....	11-38
Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажлын хүрээнд:	
3.1 Захиргааны дотоод ажлын чиглэлээр	
3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус дулаан цахилгааны хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр	
3.3 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ, хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр	
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .....	39-40
ТАВ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ.....	41-49
ЗУРГАА. ДҮГНЭЛТ.....	50

## НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэл, байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь 2021 онд удирдах төрийн захиргааны албан хаагч 1, төрийн үйлчилгээний нийт 291 ажилтан, албан хаагчийн орон тоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1041 дугаар захирамжийн дагуу Захиргаа, санхүүгийн хэлтэс, Үйлчилгээний алба, Байр ашиглалтын алба гэсэн бүтэцтэйгээр Нийслэлийн Засаг захиргааны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны “Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр батлах тухай”, 2015 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах тухай” 185 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн цэвэрлэгээ, үйлчилгээ, байр ашиглалтыг хариуцан ажиллаж байна.

Тус байгууллага нь Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагуудын хэмжээнд төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүг төлөвлөн зарцуулах, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавих, ажил үйлчилгээний төсвийг хянах, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх санхүүгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Мөн Хангарди ордны зоогийн газар, НЗДТГазар, Улаанбаатар чуулгын байруудад байрлах цайны газрууд нь төрийн албан хаагчдад зориулсан өдөр тутмын зоог болон төрийн томоохон хүлээн авалт, зоогийн үйлчилгээг технологийн дагуу үзүүлж байна.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн нийслэлийн захиргааны байгууллагууд болон төрийн албан хаагчдад нийтлэг үйлчилгээний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллагад тусгайлан заасан бодлогын баримт бичгийн заалт байдаггүй учраас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 10 заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3 заалтыг нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал:

**Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах 10 заалтуудыг хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал:**

**1. “Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого**

**1.1.1 Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.**

**1.1.1.4. Ариутгал халдваргүйтгэл хийх бодисын нөөц бүрдүүлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбай, нийтийн тээврийн хэрэгсэлд цэвэрлэгээ, халваргүйтгэлийн ажлыг тогтмол зохион байгуулна.**

Тайлант хугацаанд коронавируст /ковид-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын үндсэн үйл ажиллагааг ханган НЗЗ-ны байруудад холбогдох журам, шийдвэр, заавар, зөвлөмжийн дагуу дараах байдлаар зохион байгуулан ажиллалаа.

Засгийн газрын 45, 105 дугаар тогтоол, УОК-ын даргын 2021 оны 18 дугаар тушаал, газрын даргын 2021 оны “Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлах тухай” А/18, А/29 дүгээр тушаалуудаар баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган тайланг 7 хоног бүр нэгтгэн удирдлагад танилцуулан ажиллаж байна.

Хариуцсан НЗЗ-ны 5-н байр, НҮНТөвийн 5-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн нийт 12 байршилд 61.395м.кв талбайд Эрүүл мэндийн яамнаас өгч буй заавар зөвлөмжийн дагуу цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлж, 21.247.55 м.кв талбайд ариутгал, халдваргүйтгэлийг 5272 удаагийн давтамжтай, голомтын ариутгалыг 337 удаа тус тус хийж гүйцэтгэсэн байна.



Зураг 1. Цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн явцаас

Байруудын аюулгүй байдлыг хангаж, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэл, зоогийн үйлчилгээг чанартай, тасралтгүй, хэвийн, найдвартай явуулах үүднээс үйлчилгээнд ажиллаж буй ажилтнуудыг тогтмол халдвар хамгааллын хэрэгслээр хангаж, шаардлагатай хамгаалалтын хэрэгсэл, цэвэрлэгээний бодис, ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж болон түүний бодисын нөөцлөлтийг бүрдүүлэлт хийж ажилласан.



*Зураг 2. Шаардлагатай нөөц бүрдүүлэлтийг хийсэн байдал*

Нийт 12 байршилд Коронавируст халдварын /Ковид-19/ сэжигтэй тохиолдол илэрсэн үед ашиглах тусгаарлах өрөөг шаардагдах материалыг бэлтгэн бэлэн байдлыг ханган ажилласан.



*Зураг 3. Тусгаарлах өрөөг бэлэн болгосон байдал*

#### **1.1.1.7. Хүн амыг коронавирусын халдварын эсрэг дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулна.**

Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 1-р тун вакцинд 277, дархлаажуулалтын 2-р тун вакцинд 274, дархлаажуулалтын 3-р тунд 256 ажилтан, албан хаагч хамрагдсан байна. Үүнээс эрүүл мэндийн эсрэг заалттай 10, татгалзсан 2 ажилтан, албан хаагч тус тус хамрагдаагүй ба нийт ажилтан, албан хаагчдын 95.5% нь дархлаажуулалтын 3-р тунд хамрагдсан.

### **3. Эдийн засгийн бодлого**

#### **3.1.4. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар төсвийн алдагдлыг бууруулж, сахилга батыг сайжруулна.**

##### **3.1.4.5 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.**

Монгол Улсын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын дагуу коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж буй үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас

бусад бүх төрлийн үргүй зардлыг гаргахгүй байх үүднээс батлагдсан төсөвт зардлын дүнг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарган ажиллаж байна.

Байгууллагын худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжих хүрээнд байгууллагын зоогийн газруудын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

#### **4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**4.1.1. Төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг “Нэг цонхны үйлчилгээ”-нд шилжүүлэн, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх бага зардал, цомхон бүтэц бүхий төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.**

**4.1.1.2 Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.**

Байруудын хурлын заалны захиалгыг цахим хэлбэрээр авч, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хэрэглэгчдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын систем /ERP/-д шинэ цэс үүсгэхээр холбогдох судалгааг хийж, техникийн даалгаврыг боловсруулсан ба 2022 онд хөгжүүлэлтийг хийхээр байгууллагын төсөвт зардлыг тусган ажилласан.

**4.1.1.3 Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулна.**

Нутгийн захиргааны байгууллагуудын [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) дотоод удирдлагын систем "Дижитал Монгол" хөтөлбөрийн хүрээнд цахим хэрэглээг дэмжих, коронавирус /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, биечилсэн харилцааг багасгах зорилгоор E-DOC системийн баримт боловсруулалт модулийг ашиглан албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан тайлант хугацаанд 335 албан бичиг буюу нийт явуулсан албан бичгийн 87.5%-ийг тоон гарын үсгээр баталгаажуулан ажиллалаа.

**4.1.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлнэ.**

**4.1.2.2. “Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.**

Тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, дэд төвүүдэд авто зогсоол, орц, гарц, ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн ба НЗЗ-ны 2 дугаар байр буюу Хангарди ордны 1 дүгээр давхарт шинээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зорилсан ариун цэврийн өрөөг тохижуулж ажиллалаа.

**4.1.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.**

**4.1.4.1.“Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэнд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.**

Тайлант хугацаанд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, НЗДТГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб хуудаст 17 төрлийн тайлан, мэдээг 119 удаа тухай бүр нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.

**4.2.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.**

**4.2.2.1. “Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх авлига хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог буруулах.**

Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамраах албан тушаалын 13 албан хаагч Авилгатай тэмцэх газарт заасан хугацаанд мэдүүлсэн.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй, авлига, ашиг сонирхолын зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.

**4.2.3. Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.**

**4.2.3.1.”Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.**

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 26 арга хэмжээ төлөвлөснөөс 24 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, давхардсан тоогоор 525 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 92%-ийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал үзүүлэлт 1.6 дахин өссөн үзүүлэлттэй байгаа нь цаг үеийн нөхцөл байдалд тохируулан цахим сургалтад хамруулсантай холбоотой юм.

Дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 28 удаагийн сургалтад давхардсан тоогоор 288 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан. Үүнээс “Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт сургалтад 1 албан хаагч, “Зөв менежмент- Зөв тогтолцоо” стандарт танилцуулах сургалтад 24 албан хаагч, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, түүнийг тайлагнах, үнэлэхтэй холбоотой 4 модульт цахим сургалтад 45 албан хаагч хамрагдаж тус тус сертификат гарган авсан.

## **5. Ногоон хөгжлийн бодлого**

**5.2.6. Бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээх хүн амын эрүүл мэндийг хамгаалах, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх “Хөрсний бохирдолгүй хот” арга хэмжээг хэрэгжүүлнэ..1. Ногоон байгууламж бүхий хот**

### **5.2.6.2. Хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ.**

Нийслэлийн өнгө үзэмжийг нэмэгдүүлэхэд бид өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд хотын агаарыг цэвэршүүлж, чийгшүүлэх, шороо тоосжилт, агаар дахь хорт элементүүд, түүний дотор өвчин үүсгэгч нян, бактериудыг бууруулах, дархлааны системийг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг ажиллах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс НЗЗ-ны 5-н байр, НҮНТөвийн 4-н салбар болон Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн нийтийн эзэмшлийн гадна талбайд хаврын цэцэгжүүлэлт, ногоон байгууламж, тохижилтын үйл ажиллагааг гүйцэтгэн мод, бут, сөөгний үрсэлгээг суулган, цэцэг тарих зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн.

Манай байгууллагаас дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 34 ажилтан, албан хаач оролцож 120 мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн.

### **Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн дараах 4 заалтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал:**

#### **5. Засаглал**

**5.3. Мэргэшсэн, чадварлаг иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.**

**5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.**

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлэх хүрээнд тус газар нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ISO9001 буюу чанарын удирдлагын тогтолцооны зарчим, ач холбогдол, стандартчиллын тухай судлан, төрийн албан хаагчдад үзүүлж буй үйлчилгээний чанарын үзүүлэлтийг нэмэгдүүлэх, ажилтан, албан хаагчдын ажлын үр дүн, чанарын шаардлагыг хангуулах, хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэхээр зорин ажиллаж, үе шаттайгаар сургалтад хамруулан ажиллаж байна. Тухайлбал:

- Монголын стандарт, чанарын хүрээлэнгийн сертификаттай “Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт цахим сургалтад албан хаагч – 1;
- “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн” сэдэвт цахим сургалтад 6 албан хаагчийг тус тус хамруулсан.

**5.3.2. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.**

Байруудын хурлын заалны захиалгыг цахим хэлбэрээр авч, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хэрэглэгчдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын систем /ERP/-д шинэ цэс үүсгэхээр холбогдох судалгааг хийж, техникийн даалгаврыг боловсруулсан ба 2022 онд хөгжүүлэлтийг хийхээр байгууллагын төсөвт зардлыг тусган ажилласан.

**5.5. Шудрага ёсыг эрхэмлэн бэхжүүлэх замаар авилга, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэргийг буруулна.**



**5.5.1 Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлж, авилга, хээл хахуулийн бүх хэлбэрийг таслан зогсоож, хяналтыг нэмэгдүүлнэ.**

Тайлант хугацаанд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, НЗДТГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб хуудаст 17 төрлийн тайлан, мэдээг 119 удаа тухай бүр нь байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.

**5.5.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.**

Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар тус газрын хуулийн үйлчлэлд хамраах албан тушаалын 13 албан хаагч Авилгатай тэмцэх газарт заасан хугацаанд мэдүүлсэн.

Хүндэтгэн үзэх шалтгаанаар хойшилсон болон мэдүүлээгүй, авлига, ашиг сонирхолын зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.

## **6. Ногоон хөгжил**

**6.2 Орчны бохирдлыг багасгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.**

**6.2.3. Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна.**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-д нийцсэн ангилан ялгах хогийн савыг нийслэлийн засаг захиргааны байруудад байршуулахаар судалж, зорилтот жилийн хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах дадлыг хэвшүүлэхээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудыг уриалан зохион байгуулж, байруудад хогийг эх үүсвэр дээр нь 4 төрлөөр ангилан ялгах эко хогийн савыг шинээр байрлуулсан. Мөн байруудын доторх нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдлыг 4 төрлөөр ангилан ялгах хогийн савыг байршуулсан.



*Зураг 4. Хог ангилан ялгах эко хогийн савыг байршуулсан байдал*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**Хууль тогтоомж, НИТХ-ын тогтоол, нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг тайлагнаж ажиллах**

Тайлант хугацаанд нийт 26 төрлийн захирамжлалын баримт бичгийн 60 зүйл заалтын хүрээнд тайлан мэдээг бэлтгэж, сар улирлаар 1-4 удаагийн давтамжтайгаар заасан хугацаанд [www.monitoring.ulaanbaatar.mn](http://www.monitoring.ulaanbaatar.mn) цахим хуудаст байршуулахын зэрэгцээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахим болон цаасан суурьтайгаар хүргүүлж ажиллалаа.

2.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 12 төрлийн захирамжлалын баримт бичгийн 33 заалтын хэрэгжилтийн мэдээг улирал бүр гаргаж, НЗДТГ-т хүргүүлэн ажиллалаа. Тодруулбал:

Хүснэгт 1

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт	Тайлан өгсөн давтамж
1.	Монгол улсын хууль	1. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай	8	4
		2. Төрийн албаны тухай	1	4
2	Засгийн газрын тогтоол	3. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2018-258/	9	4
		4. Журам шинэчлэн батлах тухай /№2020-206/	2	4
		5. Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай /№2021-43/	6	3
		6. Журам батлах тухай /№2021-45/	1	2
		7. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай /№2021-93/	1	2
		8. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай /№2021-259/	1	1
		9. Нийслэлийн нутгийн удирдлагын байгууллагуудыг шилжүүлэн байршуулах тухай /№2021-282/	1	3
		10. Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай /№2021-315/	1	1
3	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	11. 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл №51	1	1
		12. 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл №55	1	1
Нийт		12	33	30

Энэ нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн өмнөх оны тоо хэмжээнээс 6 төрлийн захирамжлалын баримт бичгийн 18 заалтаар нэмэгдсэн байна.

2.2 Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын 14 төрлийн захирамжлалын баримт бичгийн 27 заалтын хэрэгжилтийн мэдээг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан. Тодруулбал:

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт	Тайлан өгсөн давтамж
1	Нийслэлийн Засаг даргын захирамж	1. Төсвийн хуваарь батлах тухай /№2021-А/10/	1	2
		2. Журам шинэчлэх батлах тухай /№2021-А/52/	1	1
		3. “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” /№2021-А/115/	1	2
		4. “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” /2021-А/357/	2	2
		5. Нийслэлийн 2020-2021 оны өвөлжилтийн дүн, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай /№2021-А/382/	1	1
		6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай /№2021-А/477/	2	1
		7. “Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” /№2021-А/667/	1	2
		8. “Ажлын хэсэг байгуулах тухай” /№2021-А/779/	1	1
		9. Хуулийн хэрэгжилтийг хангах тухай /№2021-А/828/	1	1
2	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	10. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 01 дүгээр хуралдааны тэмдэглэл	6	4
		11. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 02 дугаар хуралдааны тэмдэглэл	2	4
		12. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 14 дүгээр хуралдааны тэмдэглэл	3	2
		13. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 15 дугаар хуралдааны тэмдэглэл	4	2
		14. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 18 дугаар хуралдааны тэмдэглэл	1	1
Нийт		14	27	26

Энэ нь НЗД-ын захирамж, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн өмнөх оны тоо хэмжээнээс 3 төрлийн захирамжлалын баримт бичгийн 15 заалтаар нэмэгдсэн байна.

Нийт захирамжлалын баримт бичгийн тоо тайлант хугацаанд 2020 оныхоос 8 төрлийн захирамжлалын баримт бичгийн 33 заалтаар нэмэгдсэн байна.




График 1. Захирамжлалын баримт бичгийн тоог өмнөх онтой харьцуулсан байдал

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд:

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/666 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрэм шинэчлэн батлах тухай” дүрэмд тусгасан дараах 7 үндсэн чиг үүргийн дагуу НИТХ, НЗДТГ, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагууд болон Нийслэлийн Засаг захиргааны байруудад байрлан ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

### 3.1 Захиргаа, дотоод ажлын чиглэлээр

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох заалтуудад нийцүүлэн 2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд үйлчилгээ, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж, шинэ санал санаачилгыг дэмжин, идэвхжүүлэн урамшуулж ажиллалаа.

#### 3.1.1 Хүний нөөцийн чиглэлээр:

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тоог байгууллагын цахим хуудас [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) болон зарын нэгдсэн цахим хуудас [www.unequi.mn](http://www.unequi.mn), [www.biznetwork.mn](http://www.biznetwork.mn), байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулж нийтэд мэдээлэхийн зэрэгцээ ажлын байрны зарыг Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд ажлын байрны 60 сул орон тоонд 115 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, 50 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Мөн байгууллагын 291 ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг ханган баяжуулалт хийж ажилласан ба ажлын байрны сул орон тоонд зохих шаардлагыг хангасан 3 ажилтанг албан тушаал дэвшүүлэн томилсон байна.



Зураг 5. Нээлттэй ажлын байрны зар

Тайлант хугацаанд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан ажилтан, албан хаагчдын судалгааг тухай бүр гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан. Тухайлбал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчид;
2. Байгууллагын ахмад настнуудын;
3. Ажилтан, албан хаагчдын улсад ажилласан жил, төрийн албанд ажилласан жилийн;
4. Жирэмсэн, хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтан, албан хаагчдын;
5. 0-12, 0-15 насны хүүхэдтэй ажилтан, албан хаагчдын;

6. Өрх толгойлсон ажилтан, албан хаагчид;
7. Хугацаат цэргийн алба хаасан ажилтан, албан хаагчид;
8. Шинээр ажилд томилогдсон ажилтан, албан хаагчдын;
9. Ажилтан, албан хаагчдын оршин суугаа гэрийн хаягийн;
10. Ажилтан, албан хаагчдын дархлаажуулалтад хамрагдсан байдлын;
11. Байгууллагад хөдөлмөр эрхэлж буй залуучуудын;
12. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем дэх төрийн албан хаагчийн нэгдсэн бүртгэлийн;
13. Цалин хөлсний бүтцийн судалгаа;
14. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн

судалгааг тус тус гаргасан.

Мөн байгууллагад үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай олон жил ажилласан ажилтан, албан хаагчдыг дараах байдлаар шагналд тодорхойлсон. Үүнд: Төрийн дээд одон медальд 3, МУ-ын Засгийн газар, яамдын шагналд 24, ТЗҮЭГазрын шагналд 2, НИТХ-ын шагналд 26, НЗД-ын шагналд 19 нийт 74 ажилтан, албан хаагчдын тодорхойлолтыг тус тус бэлтгэн хүргүүлж, шагнагдсан.

### 3.1.2 Сургалт зохион байгуулсан талаар:

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 26 арга хэмжээ төлөвлөснөөс 24 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, давхардсан тоогоор 525 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 92.3%-ийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал үзүүлэлт 9.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




График 2. Өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан байдал

Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 59 удаагийн сургалтад давхардсан тоогоор 797 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан.

Үүнээс нийт 10 удаагийн сертификаттай сургалтад давхардсан тоогоор 92 албан хаагчийг хамруулж, ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлж ажиллалаа.

Байгууллагын хэмжээнд 2021 онд ажлын бус цагаар өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэн Хүмүүнлэгийн Ухааны их сургуульд хэл шинжлэлийн магистрантурт 1, Удирдлагын академид төрийн удирдлагын магистрантурт - 2, Олон улсын Улаанбаатар их сургуульд эрх зүйн магистрантурт 1, МУИС-д хүний нөөцийн ажилтнаар магистрантурт 1, Санхүү, эдийн засгийн их сургуульд бизнесийн удирдлагаар магистрантурт 1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын дээд сургуулийн ХАБЭА магистрантурт 1, ХААИС-ийн газар зохион байгуулалтын бакалаврт 1 буюу нийт 8 албан хаагч хувийн зардлаараа суралцаж байна.



Зураг 6. Зохион байгуулагдсан сургалтуудын үеэр

### 3.1.3 Тушаал шийдвэрийн талаар:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан даргын тушаал 41, Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр гаргасан даргын тушаал 147 тус тус батлагдан гарч хэрэгжилтийг ханган ажилласан болно.




График 3. Сүүлийн 4 жилийн тушаалын тоог харьцуулсан байдал

### 3.1.4 Өргөдөл гомдлын талаар:

Тайлант хугацаанд байгууллагын ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 140 өргөдөл ирснийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид биечлэн болон бичгээр танилцуулсан. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа тогтмол шинжтэй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног, 20 цаг, 33 минут байна.

Сүүлийн 4 жилийн хугацаанд буюу 2017 оноос хойш өргөдөл, гомдлын тоо тогтмол буурсан үзүүлэлттэй байна.




График 4. Өргөдөл гомдлын тоог өмнөх онуудтай харьцуулсан байдал

Тайлант хугацаанд ирсэн өргөдлийг ангилан авч үзвэл:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл - 20
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл - 16
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл - 44
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл - 23
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл - 34
- Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай өргөдөл - 2
- Бусад - 1



График 5. Ирсэн өргөдлийг төрлөөр ангилан харуулав

### 3.1.5 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамж “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/16 тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын журам”-ыг тус тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг 346 үүнээс хариутай бичиг 128, хариугүй 218 бичиг хүлээн авч холбогдох хэлтэс, албадад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан.

Ирсэн албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

№	Төрөл	Ирсэн бичгийн тоо	Ирүүлсэн хэлбэр			Шийдвэрлэлт					
			Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо	Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо	Системээр бүртгэгдсэн бичгийн тоо	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Хугацаандаа хаасан	Шийдвэрлэлтийн шатанд байгаа бичиг	Хугацаа хэтэрсэн бичиг	Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь
1.	Удирдлага	12	0	1	11	5	7	11	0	1	92%
2.	Захиргаа санхүүгийн хэлтэс	271	1	9	261	112	159	259	8	4	98.85%
3.	Байр ашиглалтын алба	50	0	8	42	9	41	48	0	1	95.55%

4.	Үйлчилгээний алба	13	0	1	12	2	11	12	1	0	100%
5.	<b>Нийт ирсэн бичиг</b>	<b>346</b>	<b>1</b>	<b>19</b>	<b>326</b>	<b>128</b>	<b>218</b>	<b>331</b>	<b>9</b>	<b>6</b>	<b>98.37%</b>

Тайлант хугацаанд 350 албан бичгийг дээд шатны байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, бусад гадны байгууллагад албан бичгийн стандарт, дүрэм, зааврын дагуу боловсруулж хүргүүлсэн ба Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс холбогдох газруудад явуулсан нийт 9367 албан бичгийг тус газрын 2 бичиг хүргэгч шуурхай хүргэж ажиллалаа.




График 6. Шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад байдал

Явсан албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4

№	Төрөл	Явсан бичгийн тоо	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Хугацаа хэтрүүлж харуу ирүүлсэн	Шийдвэрлэх шатандаа	Хугацаа хэтэрсэн, харуу ирээгүй	Шийдвэрлэлтийн хувь
1.	Удирдлага	0	0	40	0	0	0	0
2.	Захиргаа санхүүгийн хэлтэс	253	0	253	0	0	0	100%
3.	Байр ашиглалтын алба	35	0	35	0	0	0	100%
4.	Үйлчилгээний алба	2	0	2	0	0	0	100%
5.	<b>Нийт явсан бичиг</b>	<b>290</b>	<b>0</b>	<b>290</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>100%</b>



Хэвлэмэл хуудасны тайлан тооцоо

Хүснэгт 5

Он	Хэвлэмэл хуудас	Нийт дүн	Устгасан	Ашигладсан хэвлэмэл хуудас	Үлдэгдэл
2021 он	A4 /тушаал/	1000	20	598	382
	A5	1000	15	346	639

Байгууллагын 2020 он үүсч хөтлөгдсөн 276 хадгаламжийн нэгжийг 2021 оны 1 дүгээр улиралд акт үйлдэн хүлээн авснаас цаасан суурьтай 280, тусгай төрлийн 41 хадгаламжийн нэгжийг байнга, түр хадгалахаар хугацаагаар ангилсан.

Байгууллагын үйл ажиллагаанаас 2020 онд үүсч хөтлөгдсөн 276 хадгаламжийн нэгжийг 2021 оны 1 дүгээр улиралд “Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын архивын дүрэм”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын дагуу ангилж нэр төрөл хугацаагаар нь төрөлжүүлж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авсан.

2020 оны ХХНЖ-ын дагуу хүлээн авсан баримтын нэгдсэн тоо мэдээ

Хүснэгт 6

Хэлтсийн нэр	Байнга хадгалах	70 жил хадгалах	Түр хадгалах	Тусгай төрөл	ХН-ийн тоо
Захиргаа, санхүүгийн хэлтэс	55	24	160	-	239
Байр ашиглалтын алба	19	-	7	-	26
Үйлчилгээний алба	2	-	9	-	11
<b>Дүн</b>	<b>76</b>	<b>24</b>	<b>176</b>	<b>-</b>	<b>276</b>

Байгууллагын газрын даргын 2020 оны үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан А/01-78, боловсон хүчний чиглэлээр гаргасан Б/01-353 нийт 431 тушаалыг ArchiveEdoc цахим програмд тушаалын тэргүү, агуулга, он цагийн хязгаарыг шивэх, цахим хувийг хавсаргах гэх мэт ажлуудыг гүйцэтгэлээ. Архивын цахим програмд бүртгэгдсэн захирамжлалын баримтад нягтлан шалгалт хийсэн ажлын мэдээ, тайланг Нийслэлийн Архивын газарт илгээсэн.

Архивын өрөөнд цэвэрлэгээний график төлөвлөгөөний дагуу сард 4 удаа чийгтэй цэвэрлэгээ хийлгэж, улиралд нэг удаа буюу нийт 4 удаа хортон шавьж, мэрэгч амьтны устгалын хор халдваргүйжүүлэлт, ариутгал хийлгэсэн. Мөн чийг дулааныг 7 хоногт 2 удаа хэмжиж, агаарын урсгалыг тэнцвэржүүлэх тал дээр анхаарч, тогтмол бүртгэл хөтлөн, хяналт тавин ажиллаж байна.



Зураг 7. Архивын өрөөнд хяналт тавин ажилласан байдал

Тайлант хугацаанд иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу нийт 93 баримтад лавлагаа олгож, хуулбар үнэн тэмдэгт дарж, бүртгэл хөтөллөө.


Тайлант хугацаанд архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг мөрдөн ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор холбогдох албан хаагчийг Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан сертификаттай сургалтад үе шаттайгаар хамруулан ажиллалаа. Тухайлбал:

- 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй”
- 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 23-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан “Төрийн архивын баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх, нөхөн бүрдүүлэлтээр баримт хүлээн авах, данс, бүртгэл үйлдэх арга зүй”
- 2021 оны 08 дугаар 27-ны өдрөөс 31-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан “Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй”



Зураг 8. Сургалтын үеэр

ЗГ-ын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн дагуу монгол бичгийн анхан шатны сургалтыг “Монгол бичгээ сурцгаая” уриатайгаар видео хэлбэрээр бэлтгэж, байгууллагын группд байршуулсан.



Зураг 9. Монгол бичгийн видео хичээл бэлтгэн явуулж буй байдал

### 3.1.6 Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтвор суурьшлыг хангах, ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 3 чиглэлийн 26 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттайгаар

шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж нь хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангаж ажиллалаа. Тухайлбал:

Тайлант онд сар шинийн баяр, аравдугаар сарын 01-ний өдөр ННҮГ-ын ахмадуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан.

Өндөр насны тэтгэвэрт гарсан 2 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламжид 9.826.566 төгрөг, ар гэрийн гачигдал гарсан 34 ажилтан, албан хаагчид өргөдлийг үндэслэн 44.508.131 төгрөг, цалин хөлсөнд 1.523.826.909 төгрөг, урамшуулалд 225.714.062 төгрөг, мөн ажилтан, албан хаагчдын хоол, тээврийн зардалд 250.032.229 төгрөгийг тус тус олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, тус газрын “Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу 2021 онд нийт давхардсан тоогоор 275 ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийг үр дүнг улирал бүр үнэлж, 225.714.062 төгрөгийн урамшуулал олгон ажилласан.

Газрын даргын 2020 оны А/51, 2021 оны А/26, А/39, А/48 дугаар тушаалуудаар ажилтан, албан хаагчдын 2020 оны 4 дүгээр улирал, 2021 оны 1, 2, 3 дугаар улирлын ур чадварыг дүгнэх ажлын хэсгийг байгуулан ур чадварыг дүгнэж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу нийт 212.415.424 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгосон байна.

Ажилтан, албан хаагчдын амьдрах орчинг сайжруулж амьдралын баталгаа, ажлын тогтвор суурьшлыг хангах зорилгоор НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт хүсэлт гаргасны дагуу байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан 2 ажилтанд иж бүрэн гэр олгосон.



Зураг 10. Гэр олгох батламж гардуулж буй явцаас

### 3.1.7 Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 1.1.1. дэх хэсэг “Цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.” гэж заасны дагуу цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд Коронавируст халдвараас (Ковид-19) урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, ажлын байранд Ковид-19-ийн эрсдэлт нөхцөл байдал үүсвэл авах арга хэмжээ, цар тахлын үед хөдөлмөр зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулах чиглэлээр дараах байдлаар сургалтад хамруулсан. Тухайлбал:

- МҮЭХ-ны Залуучуудын хороо, ХБНГУ-ын ФЭС-тай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан "Хөдөлмөрийн эрүүл ахуй ба Ковид-19" сургалтад 20 албан хаагч;
- МҮЭХ-ны Залуучуудын хороо, ХБНГУ-ын ФЭС-тай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан "ХАБЭА-ийн өнөөгийн байдал, цаашдын бодлого чиглэл" сургалтад 11 албан хаагч;
- МҮЭХ-ны Залуучуудын хороо ХБНГУ-ын ФЭС-тай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого ба залуучууд" сургалтад 20 албан хаагч
- ЗАА, Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-тай хамтран 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх" сэдэвт сургалтад 50 ажилтан, албан хаагчийг тус тус хамруулсан.

Коронавируст /Ковид-19/ халдварын өвчлөл буурахгүй байгаатай холбоотойгоор их эмч Н.Энхзаяа 2021 оны 05 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 7-ны өдрийн тушаалаар коронавируст халдварын эсрэг вакцины дархлаажуулалтад нэмэлт зохицуулалт оруулсан талаарх мэдээлэл болон дархлаагаа хэрхэн дэмжих талаар зөвлөгөөг хүргэн ажилласан.



Зураг 11. Сургалтын явцаас

Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 382 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Биеийн тамир спорт хамтлаг нь цар тахлын үед ажилтан, албан хаагчдын дархлааг дэмжих, ажиллах урам зориг, эрч хүч бэлэглэх зорилгоор "Дархлаагаа дэмжиж эрч хүчтэй, эрүүл амьдарцгаая" уриатайгаар "Дархлаажуулалтын аян"-ыг 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Тус аянаар байгууллагын нийт 300-н ажилтан, албан хаагчдад дархлаажуулалтын багцыг өглөө.



Зураг 12. Дархлаажуулалтын аяны явцаас

Биеийн тамир спорт хамтлагаас “Оюу-Шүр мед” эмнэлэгтэй хамтран 2021 оны 11 сарын 03-12 өдрүүдийн хугацаанд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг амжилттай зохион байгуулав. Тус эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 250 ажилтан, албан хаагч хамрагдаж, цусан дахь Д витамин, элэгний хавдрын маркер үзэж, ЭХО, зүрхний цахилгаан бичлэг хийж, цээж гэрэлд харах, дотор, эмэгтэйчүүд, мэдрэлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийлгэлээ.



Зураг 13. Шинжилгээнд хамрагдаж буй явцаас

### 3.1.8 Биеийн тамир спортын талаар:

Байгууллагын 25 жилийн ойг угтан биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчлах, ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд волейболын нөхөрсөг тэмцээнийг 2021 оны 12 сарын 04-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Спортын наадамд байгууллагаас 16 баг 140 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, тэргүүн байрыг Г.Батзаяа ахлагчтай Захиргааны-3-р баг, 2 дугаар байрт А.Нямсүрэн ахлагчтай НЗЗ-ны 3-р байрны баг, 3 дугаар байрт Х.Долгормаа ахлагчтай НЗЗ-ны 2-р байрны 1-р баг тус тус шалгарсан.



Зураг 14. Тус тэмцээнд шалгарсан багууд

### 3.1.9 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч 7, агентлаг хариуцсан нярав 6 албан хаагчаар дамжуулан иж бүрнээр үзүүлэн ажилласан. Тайлант онд буюу 2020 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар аудитын газраас 4 акт, 7 албан шаардлага, 40 зөвлөмж өгсөн. Дээрх үзүүлэлтийг бууруулж ажиллахаар зорилт тавин ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө санхүүг төлөвлөн зарцуулж, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавин, ажил

үйлчилгээний төсвийг хянан, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан.

Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст холбогдох 17 төрлийн тайлан, мэдээг гаргаж, тухай бүр нь буюу тогтоосон хугацаанд нь нийт 119 удаа байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын санхүүгийн тайлан мэдээг цаг тухайд нь гарган нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажилласан. PAYROL-Цалингийн програмд нийт ажилтан албан хаагчдын цалингийн тооцоо, бүртгэл мэдээллийг сар бүр тушаал шийдвэрийн дагуу хөтөлж, шинэ ажилчдын мэдээллийг бүртгэн, “Төрийн Албаны нэгдсэн систем”-ын цалингийн программд ажилчдын цалингийн тооцооллыг хийж ажиллаж байна. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг хангаж, эд хариуцагчийн картын дотоод хөдөлгөөнийг Acolous програмд бүртгэлжүүлэн хөрөнгийн шилжилтийг эд хариуцагчид картласан. Эд хөрөнгийн тооллогыг тайлант онд 2 удаа зохион байгуулж, 23.645.525 төгрөгийн 23 нэр төрлийн үл хөдлөх хөрөнгө, 38.000.000 төгрөгийн 1 тээврийн хэрэгслийг актлах саналыг холбогдох газарт хүлгүүлж шийдвэрлүүлсэн ба эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг картаар дамжуулан бүртгэлжүүлж өглөг, авлага үүсгэлгүй ажилласан.

Бараа материалын тайланг сар бүр гарган, түлш, шатах тослох материалын тооцоог бодож НББ-ын үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу хөтлөн эд хөрөнгө бараа материалын хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд агуулахын эд хөрөнгийг тус тус эмхэлж цэгцэлж, ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийж ажилласан. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбоотой ямар нэгэн зөрчилгүй, гуравдагч этгээдээс гаргасан гомдолгүй ажиллаа.

### 3.1.9 Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”, 2014 оны А/279 дүгээр захирамжаар баталсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”, бусад холбогдох дүрэм, журам, баримт бичгийг тус тус удирдлага болгон ажилласан.

#### Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, бусад холбогдох дүрэм, журмын дагуу бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээний хийж ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагаанд холбогдох захирамжлалын баримт бичгийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) цахим хуудсанд тус тус байршуулан нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын 2 хуулийн 9 заалт, Засгийн газрын 8 тогтоолын 22 заалт, Засгийн газрын 2 хурлын тэмдэглэлийн 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 9 захирамжийн 11 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 5 тэмдэглэлийн 16 заалтын хэрэгжилтэд тус тус хяналт тавин ажиллалаа. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 98%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний хэрэгжилт 98.7%, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох арга хэмжээний хэрэгжилт 98%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний календарьчилсан хуваарийг 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Газрын даргын баталсан удирдамжийн дагуу байгууллагын үйл ажиллагаанд 10 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай зөвлөмж өгч ажиллалаа. Үүнд:

1. Засгийн газрын 45 дугаар тогтоол, УОК-ын даргын 2021 оны 18 дугаар тушаалаар, “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хэрэгжилт
2. НЗЗ-ны байруудад “Нөөц түлхүүр байршуулах, хүлээлцэх” журмын хэрэгжилт,
3. Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа;
4. НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал халдваргүйжүүлэлтэд
5. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ;
6. Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа;
7. НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал халдваргүйжүүлэлт;
8. Байр ашиглалтын албаны үйл ажиллагаа;
9. Үйлчилгээний албаны үйл ажиллагаа;
10. Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Сэтгэл ханамжийн судалгааны талаар:

Тус газар нь байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа авахаар төлөвлөдөг. Гэвч цаг үеийн нөхцөл байдлын улмаас 2021 оны эхний хагас жилийн сэтгэл ханамжийн судалгааг хойшлуулсан ба сүүлийн хагас жилийн сэтгэл ханамжийн судалгааг НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвд үйл ажиллагаа явуулж байгаа ННЗБ-ын албан хаагчдаас 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулсан. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг ERP системийн “Судалгаа” цэсээр цахим хэлбэрээр зохион байгуулж нийт 860 ажилтан, албан хаагчид оролцож санал хүсэлтээ өгсөн. Судалгааны дүнгээс харахад манай байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд судалгаанд оролцогчдын 63% буюу дийлэнх хэсэг нь сайн үнэлгээ өгсөн ба төрийн албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтийг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах үүргийг холбогдох албан хаагчид өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.




График 7. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

### 3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус, дулаан, цахилгаан, хурлын танхимуудын техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр:

ННҮГ-ын Байр ашиглалтын алба нь албаны дарга 1, инженер 4, нийт 50 хүний бүрэлдэхүүнтэйгээр НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ, инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, хэвийн жигд ажиллагааг ханган ажиллаж, НЗЗ-ны 5-н байранд байрлан төрийн үйлчилгээ үзүүлж буй Нийслэлийн нутгийн захиргааны 32 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг 24 цагаар тасралтгүй шуурхай үзүүлж ажиллаж байна.

Инженерийн шугам сүлжээг эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг албаны дарга сард 1 удаа, инженерүүд 14 хоног тутам тус тус тогтмол хийж, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, техникийн болзошгүй саатлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө, НЗЗ-ны байруудын хаврын тохижилтын ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд инженерийн байгууламж, засвар үйлчилгээтэй холбоотой нийт 4527 дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан ба 2020 онтой харьцуулахад 68%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь 2021 онд Хотын захиргааны шинэ цогцолборыг хүлээн авсантай холбоотой юм.





График 8. Тайлант хугацаанд БАА-нд ирсэн нийт дуудлагын төрөл





*График 9. Тайлант онд ирсэн нийт дуудлагыг өмнөх онуудтай харьцуулбал*

### 3.2.1 Цахилгаан хангамжийн чиглэлээр:

НЗЗ-ны байруудын цахилгааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулж, цахилгаан ашиглалттай холбоотой 1355 дуудлага ирснийг шуурхай засварлаж ажиллалаа.

НЗЗ-ны байруудын цахилгаан эрчим, хүчний аюулгүй байдлыг хангах, хэмнэлтийг бий болгох, цахилгааны хэвийн ажиллагааг хангах зорилгоор Зүүн Цахилгаан Түгээх салбартай хамтран ажиллах гэрээний дагуу тоолуур, гүйдлийн тр-р баталгаажуулах хуваарилах байгууламжуудын тоолуурыг шинээр сольж, ил гарсан цахилгааны болон, холбоо, сүлжээний утсыг далдалж аюулгүй байдлыг бүрэн ханган ажилласан.

Цахилгаан, эрчим хүчний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах зорилгоор 2021 онд зарим засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



*Зураг 15. Гадна орчны аюулгүйн үзлэгийн үеэр*



*Зураг 16. 5-р байрны цайны газрын цахилгааны шийд сольсон*



*Зураг 17. НЗЗ-ны 4-р байрны ерөнхий шитэнд ээлжит урсгал засварыг хийсэн*



*Зураг 18. Баянхошуу дэд төвийг үндсэн ХТП-6575 дэд станцын схемд холбосон*



Мөн НЗЗ-ны 5А байранд 2021 оны 11-р сарын 15-ны өдрөөс 21-нийг хүртэлх хугацаанд Төрийн албаны ерөнхий шалгалтын үеэр УБЦТС-тэй хамтран ХТП-0752 дэд станцын 2-р ячокны 4-р групп буюу нийслэлийн Улаанбаатар чуулгын тайзны кабелийг дизель генераторт холбож, шалгалтын хугацаанд цахилгаан хангамжийг доголдолгүй ханган ажиллалаа.




График 10. Цахилгааны хэрэглээг өмнөх онуудтай харьцуулсан байдал

### 3.2.2 Сантехник, инженерийн шугам сүлжээний чиглэлээр:

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн сантехникийн шугам сүлжээ, агааржуулалтын хоолойн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж, нийт 1323 дуудлагыг бүртгэн шуурхай барагдуулж ажилласан бөгөөд НЗЗ-ны байруудын халаалтын хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Сантехник, инженерийн шугам, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор зарим засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

Тайлант онд 2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөг хангах хүрээнд бохир ус зайлуулах нийт 26 худгийг лайдаж цэвэрлэж, урсгал засвар үйлчилгээний ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. НЗЗ-ны байруудын ашиглалтын шаардлага хангахгүй болсон шугам хоолойн холбох хэрэгсэл, хаалт, угаагуур, суултуурыг дараах байдлаар шинэчиллээ.



Зураг 19. НЗЗ-ны 2-р байрны ариун цэврийн өрөөний агааржуулагчийн хоолойг сольсон



Зураг 20. НЗЗ-ны 2-р байрны цэвэр усны босоо шугам сольсон



Зураг 21. АЦӨ-ний шугам ханан дунд цоорсныг Р20-ийн цагаан шугамаар сольсон



Зураг 22. Дунжингарав салбарын ариун цэврийн өрөөний угаалтуурын холигчийг шинэчилсэн





**Зураг 23. 5Б корпуст өрөөний агааржуулалтын сэнсийг суурилуулсан**



**Зураг 24. Мишээл салбарын ариун цэврийн өрөөнүүдэд засвар хийсэн**



**Зураг 25. Н33-ны 1-р байрны цайны газрын гоожуурыг шинэчилсэн**



**Зураг 26. Н33-ны 1-р байрны бохирын шугамыг цэвэрлэж тройнек сольж буй байдал**



**Зураг 27. Н33-ны 1-р байрны Цахилгаан бойлер шинэчлэн угсарч суурилуулж буй байдал**



**Зураг 28. Н33-ны 2-р байрны Ялтсан бойлерын хүчин чадлыг нэмэгдүүлж шинэчлэх явцаас**



**Зураг 33. Н33-ны 4-р байрны Автомат хаалт болон шугам хоолойг сольж шинэчлэх явцаас**



**Зураг 34. Драгон салбарын ариун цэврийн өрөөнүүдэд засвар хийсэн**



Тайлант хугацаанд НЗЗ-ны 5-н байр болон Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд ашигласан усны хэрэглээ нь 8665 тн байгаа нь 2020 оны мөн үетэй харьцуулбал 77.3 хувиар буурсан нь сантехникийн холбох хэрэгсэл болон шугам хоолойн гэмтлийг цаг алдалгүй засварласнаар усны үр ашиггүй зарцуулалтыг багассан эерэг үзүүлэлт гарсан байна.




График 11. Усны зарцуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал




График 12. Байруудын 2021 оны усны зарцуулалтыг харьцуулбал



График 13. Дулааны хэрэглээг мөнгөн дүнгээр харьцуулсан байдал

Тайлант хугацаанд НЗЗ-ны 2, 4-р байрны хүн зөөврийн болон ачааны нийт 6 цахилгаан шатны хэвийн найдвартай үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, сар бүр гэрээт байгууллагаар ашиглалт, засвар үйлчилгээг гүйцэтгүүлж, цахилгаан шатны магадлалыг жилд 1 удаа тогтмол хийлгэж лифтний аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа.



Зураг 29. Лифтний хонгилын гэрлийг солих явцаас



Зураг 30. Лифтний товчлуурыг шинэчилж буй явцаас



3.2.3. НЗЗ-ны байруудын хурлын танхим, хяналтын камеруудын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр

Байруудын хяналтын камерийн хэвийн ажиллагаан хангах зорилгоор тайлант хугацаанд 13 ширхэг камер, 2ш дэлгэц, 1 ширхэг хатуу диск, НЗЗ-ны 2-р байрны хурлын заалны WGA кабелийг HDMI кабелаар тус тус сольж, шинэчлэн хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.



Зураг 31. Хангарди ордонд үзүүлэлт сайтай камер нэмж суурилуулсан байдал



Зураг 32. Хангарди ордны хурлын заалны WGA кабелийг HDMI кабелаар сольсон байдал



Зураг 33. НЗЗ-ны 3-р байранд NVR 3тр нягтралтай камер, 14инчтэй дэлгэц, 8 port свич зэргийг сольсон



Зураг 34. НЗЗ-ны 4-р байранд 32 сувагтай NVR 2.5tb хард, 3тр нягтралтай камер шинээр суурилуулсан



Тайлант хугацаанд НИТХ, НЗД-н шуурхай, НЗД-ын зөвлөлийн хурал, шагналын арга хэмжээ болон бусад хурлын үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмжийн бэлтгэл ажлыг хангаж, ямар нэгэн доголдолгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрэн хангаж ажиллалаа.


Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын [www.Khangardi.mn](http://www.Khangardi.mn) цахим хуудсыг хөтлөлт, хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж, мэдээллийн болон техникийн аюулгүй байдлын ханган ажиллаж, аливаа цахим халдлагаас урьдчилан сэргийлж ажилласан байна. Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим сайтуудын хөтлөлтөд хийсэн шалгалтаар манай байгууллагын 2021 оны эхний улиралд тэргүүн байрт шалгарсан. Мөн мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, байгууллагынхаа цахим хуудсыг англи хэл дээр танилцуулдаг болгох үүрэг даалгаврын дагуу <http://khangardi.mn/> цахим сайтыг англи хэлний сонголттой болгон хөгжүүлсэн.



Зураг 35. Сайтыг англи, монгол хэлний сонголттой болгосон байдал

### 3.2.4. НЗЗ-ны байруудын засвар үйлчилгээний чиглэлээр

НЗЗ-ны 1 дүгээр байрны амрах өрөө, хүзүүвч, ажлын өрөөнүүд, чийрэгжүүлэх танхим, гадна фасад болон 2700м<sup>2</sup> талбай бүхий дээврийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 36. Дээврийн засварын ажил

Зураг 37. Гадна фасадны засварлаж буй явцаас



Зураг 38. Амралтын өрөөний таазны засвар хийж буй явцаас

Зураг 39. Амралтын өрөөний тосгуурын засвар хийж буй явцаас



Зураг 40. Ажлын өрөөний засварын явц

Зураг 41. Хүзүүвч, чийрэгжүүлэх өрөөг засварлав



Зураг 42. НЗЗ-ны 2-р байрны 16 давхрын шилэн дээврийн засвар хийгдсэн байдал



Зураг 43. НЗЗ-ны 4-р байрны 4 давхрын дээврийн хар цаас хууларсныг засварлав



Зураг 44. НЗЗ-ны 5-р байрны В корпусын дээврийн хар цаас цоорсоныг засварлав



Зураг 45. НЗЗ-ны 4-р байрны нийтийн эзэмшлийн талбайг будаж засварлав



Зураг 46. НЗДТГ-ын цайны газарт засвар хийсэн байдал

### 3.3. Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ, хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр:


#### 3.3.1 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээ

Өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд байгууллагад мөрдөгдөж буй Байгууллагад мөрдөгдөж байсан Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага (ННҮГ-01:2019)-ыг 2020 онд UCS0201B “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” болгон шинэчилж, нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/276 дугаар захирамжаар стандартын удирдамж арга зүйн баримт бичиг болон батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

НЗЗ-ны 5-н байр, ННҮТөвийн 4-н салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төв болон Хотын захиргааны шинэ цогцолборын А блок буюу нийт 61.395м.кв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлж, цэвэрлэгээний давтамжийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2 цаг тутамд ариутгалын бодистой чийгтэй цэвэрлэгээг 5475 удаа, ариун цэврийн өрөөний

цэвэрлэгээг 5845 удаа, хуваарийн дагуу их цэвэрлэгээг 645 удаа тус тус хийж гүйцэтгэсэн. Байгууллагын цахим хуудсанд өдөр бүр ажлын үйл явц байдлыг байршуулан, ажлын гүйцэтгэлд байр хариуцсан менежерүүд давхар хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажилласан.



Зураг 47. Шинэчилсэн Стандарт арга зүйн баримт бичиг



Зураг 48. Өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээ хийж буй явцаас



Зураг 49. Нийтийн эзэмшлийн их цэвэрлэгээний үеэр



НЗЗ-ны байруудын нийт талбайн хэмжээ 2021 онд 61.395м<sup>2</sup> болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.7%-иар өссөн нь Хотын захиргааны шинэ цогцолборын А блокийн ашиглалтыг хариуцан хүлээн авч ажиллаж байгаатай холбоотой юм.




График 14. Нийт талбай өсөлтийг графикаар үзүүлбэл

Тайлант хугацаанд цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс цэвэрлэгээний багаж, тоног төхөөрөмжид тоос сорогч 10, өндрийн цэвэрлэгээнд хэрэглэх шат 8, өвлийн улиралд цэвэрлэгээ үйлчилгээнд шаардагдах 21 төрлийн 732 ширхэг багажийг тус тус шинээр ханган ажиллалаа. Үйлчилгээний гадна талбайн ажилтан 11, байрны жижүүр 18 ажилтны нормын хувцсыг тус тус шинэчилсэн.



Зураг 50. Шинэчилсэн ажлын хувцас

Мөн “Хогоо ангилж хэвшүүлцгээе” уриатайгаар нийслэлийн засаг захиргааны байруудад хог хаягдлын ангилан ялгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн хэвшүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд дахивар нөөцийг ангилан ялгах “ТӨВШИН САЙХАН” төвтэй хамтран картон цаас болон хуванцар савыг төрөлжүүлэн ангилж, нийлүүлж эхэлсэн.



Зураг 51. Хогийг төрөлжүүлэн ангилж буй байдал

Зураг 52. Хуванцар савыг цуглуулах хогийн савыг шинээр хийсэн

Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэнтэй хамтран “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах” сэдэвт давтан сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Тус сургалтад нийт 10 байршлаас 118 ажилтан, албан хаагч

хамрагдаж өмнөх мэдлэгээ бататгаж, шинээр орсон ажилчдад хог ангилан ялгах мэдлэгийг олгосон юм.



Зураг 53. Сургалтын үйл явц



Зураг 54. Хог ангилалт тээвэрлэлтийн явц

### Байруудын гадна орчны цэвэрлэгээ үйлчилгээний талаар

НЗЗ-ны байрууд гаднах орчны аюулгүй байдлыг ханган өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн тухайн байруудын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайг халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж, орчны 50 метр хүртэлх 24.450мкв талбайн цас, мөс цэвэрлэх, өдөр тутмын болон дээврийн цэвэрлэгээг нийт 239 удаа, их цэвэрлэгээг 174 удаа тус тус хийж, жилийн эцсийн байдлаар нийт 3470 удаа гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Тайлант онд гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээний тоо өмнөх оны мөн үеэс 23.5%-иар нэмэгдсэн байна.



Зураг 55. Гадна талбайн их цэвэрлэгээний үеэр



Зураг 56. Байруудын гадна талбайн их цэвэрлэгээний явцаас

### Ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар

Тайлант хугацаанд коронавируст халдвар /Ковид-19/- ын эсрэг хариу арга хэмжээ авах хүрээнд нийслэлийн засаг захиргааны байруудын 61.395 м.кв талбайд нийт 5272 удаа ариутгал, халдваргүйтэл хийж гүйцэтгэн ажиллалаа. “Түвшин төгөлдөр”ХХК-тай хамтран хортон шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу НЗЗ-ны 1, 2, 5А байруудын зоог, цайны газруудад 6 удаа, мэргэжлийн байгууллагаар голомтын ариутгалыг 337 удаа тус тус хийлгэсэн ба ариутгал халдваргүйжүүлэлтийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал 29 дахин өссөн нь цар тахлын нөхцөл байдалтай холбоотой юм.



Зураг 57. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй явцаас



График 15. Ариутгал, халдваргүйтэл хийгдсэн тоог харьцуулбал

Тохижилт, үйлчилгээний талаар:

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллахын зэрэгцээ төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр байруудын гадна болон дотор талын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

НЗЗ-ны байруудын гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, орчны тохижилтыг сайжруулах зорилгоор НЗЗ-ны байруудын гадна талбайд цэцгийн мандал, үрсэлгээг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал:



*Зураг 58. Ногоон байгууламж, гадна тохижилтоор хийгдсэн ажлуудаас*

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас “Шарилжгүй Улаанбаатар” зургаа дахь удаагийн аяныг хоёр үе шаттайгаар эхлүүлсэнтэй холбогдуулан Төрийн албан хаагчид болон иргэдийг шарилжаас үүдэлтэй харшлын эмгэгээс хамгаалах үүднээс байруудын нийтийн эзэмшлийн талбайд ургасан шарилж, лууль, зэрлэг ургамлыг цэвэрлэж устгах ажлыг хийж гүйцэтгэсэн.



*Зураг 59. Ногоон байгууламжийн шарилж, лууль, зэрлэг ургамлыг цэвэрлэгээний явцаас*

### 3.3.2 Хоол, цай, зоогийн үйлчилгээ

Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар чуулгын цайны газруудаар нийтийн хоол, хүндэтгэлийн хүлээн авалт, цай завсарлага, катеринг үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна. Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 90 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Эрүүл чанартай хоол хүнс бэлтгэх, хүнсний бараа материалыг гэрээний дагуу худалдан авахдаа эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийн хамт хүлээн авдаг. Мөн зоогийн газар, цайны газруудын ажилтнуудыг ЧД-ийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд 2 удаа хамруулан хоол хүнсний эрүүл ахуйг хангаж ажилласан.

Хоол үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мэргэжил тус бүрээр нь шинэчлэн, аюулгүй ажиллагааны 18 самбарыг байршуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, даавуун эдлэлийг шинэчилсэн.



Зураг 60. Хүндэтгэлийн үйлчилгээний үер өмсөх ёслолын хувцас

### Нийтийн хоолны үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд Хангарди ордны зоогийн газар 17138, НЗДТГ-ын цайны газар 15407, НЗЗ-ны 5-р байрны цайны газар дамжуулан 4104, Нийслэлийн онцгой комиссын албан хаагчдад өдөрт 2 удаа буюу 21191 нийт 57840 орчим хүнд халуун хоол, цайны үйлчилгээг тус тус үзүүлэн ажиллалаа.

Хоолны технологи картыг шинэчлэн 108 нэр төрлийг боловсруулж, Хангарди нэрийн салат, Хангарди нэрийн шөл, Япон стейк, Хурганы махан стейк зэрэг 10 шинэ нэр төрлийн хоолыг хүлээн авалтын үйлчилгээндээ нэвтрүүлж, хоол үйлдвэрлэлд мөрдөгдөх бүртгэлийн маягтуудыг 9 төрлөөр тогтмол хөтлөн ажилласан.

Зоогийн газраас гарч буй бүтээгдэхүүний хоолны сав, баглаа боодлыг стандартын шаардлага хангасан материалаар хийсэн хэрэглэгдэхүүн хэрэглэж, хүлээн авалтын ширээ засалт түүнд хэрэглэгдэх зүйлсийн жагсаалт гаргаж зарим зүйлсийг үе шаттайгаар худалдан авч, хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй түүхий эдийн чанарт анхаарч, хадгалалтын горимыг мөрдүүлэн ажиллаж, шаардлагатай эд зүйлсийг нэмэгдүүлэн ажилласан.



Зураг 61. Хоол зоогийн үйлчилгээ үзүүлэхдээ эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллалаа



Зураг 62. Өглөөний цайны бэлтгэл ажлын үйл явцаас

### Хүлээн авалтын заал, цайны газрын тохижилтын талаар

Тайлант хугацаанд зоогийн хүлээн авалтыг 129 удаа 3084 хүнд, хээрийн болон зөөврийн үйлчилгээг 6 удаа 792 хүнд тус тус үзүүлж, нийт 5390 хүнд шуурхай чанартай үзүүлж ажилласан ба үйлчилгээтэй холбоотой санал гомдол гараагүй байна.



Зураг 63. Хүлээн авалтын явцаас



Зураг 64. Өглөөний цай болон катеринг үйлчилгээний үеэр

Нийслэлийн 382 жилийн ойн баярын хүрээнд үе үеийн Нийслэлийн удирдлагуудад хүндэтгэлийн үйл ажиллагаа, Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт байрлах гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд нийт 200 гаруй хүнд тус тус хоол, зоогийн үйлчилгээг хээрийн нөхцөлд чанарын өндөр түвшинд үзүүлж ажилласан.



Зураг 65. Хурлын цай завсарлагын үйлчилгээний үеэр

### 3.3.3 Хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр:

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор нийслэлийн засаг захиргааны байруудын хурлын заал танхимд Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах хурал, зөвлөгөөний тоо буурч цаг үеийн нөхцөл байдалд тодорхой зарлагдсан хурлууд хийгдсэн.

Хуралдааны танхимд явагдах арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, график хуваарьт оруулан, хуваарийн дагуу хөнгөн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлж ажилласан. 2021 оны

байдлаар Хангарди ордны хурлын танхимуудад нийт 539 удаагийн үйл ажиллагаа хүлээн авч хурлын үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт 7

№	Хурлын чиглэл	Хуралдсан тоо
<b>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</b>		
1.	Удирдлагын зөвлөлийн хурал	16 удаа
2.	Нийслэлийн шуурхай	42 удаа
3.	Бусад	519 удаа
4.	Цайны завсарлага	40 удаа
5.	Шагнал	20 удаа
6.	ЗАА шуурхай	1 удаа
7.	НИТХ-ын чуулган	13 удаа
Нийт		651

Хурлын цай завсарлагын үйлчилгээг стандартын дагуу эрүүл ахуйн найдвартай баталгаатай хүнсээр хангасан цайны завсарлагааны үйлчилгээг жилийн эцсийн байдлаар 40 удаа 1514 хүнд үйл ажиллагааны бэлтгэл ажлыг бүрэн хангаж, шуурхай чанартай үзүүлсэн.



Зураг 66. Хурлын цай завсарлагын үйлчилгээний үеэр

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

Хүснэгт 8


№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
<b>Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал</b>			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус газар нь байгууллагын дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, дүрмээр хүлээсэн чиг үүрэгт нийцүүлэн боловсруулж, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг тухай бүр нь байгууллагын цахим хуудаст шинэчлэн байршуулж ажиллаж байна. <a href="http://khangardi.mn/?page_id=3648">http://khangardi.mn/?page_id=3648</a> <a href="http://khangardi.mn/?page_id=3634">http://khangardi.mn/?page_id=3634</a> Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын схемийг мэдээллийн самбар, цахим хуудаст тогтмол байршуулж ажилласан. <a href="http://khangardi.mn/?page_id=3868">http://khangardi.mn/?page_id=3868</a>	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тус газрын албан хаагчдын холбоо барих утас, холбогдох бусад мэдээлэл, иргэд хүлээн авч уулзах цагийн хуваарийг байгууллагын цахим хуудаст байршуулж, тогтмол шинэчилж ажиллалаа. <a href="http://khangardi.mn/?page_id=3668">http://khangardi.mn/?page_id=3668</a> <a href="http://khangardi.mn/?page_id=3672">http://khangardi.mn/?page_id=3672</a> <a href="http://khangardi.mn/wp-content/uploads/2021/03/005.jpg">http://khangardi.mn/wp-content/uploads/2021/03/005.jpg</a>	100%
3.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль огтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, журам эрх зүйн актыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, тогтмол шинэчилж ажиллалаа. <a href="http://khangardi.mn/?page_id=4047">http://khangardi.mn/?page_id=4047</a>	100%
4.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Нийслэлийн дүүргүүдийн Тамгын газрын цэвэрлэгээ, үйлчилгээ хариуцсан аж ахуйн тасаг, нийтлэг үйлчилгээний алба, ОНӨААТҮГ-ийн удирдлага, албан хаагчдын дунд UCS0202B:2020 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" баримт бичгийг сурталчлан таниулах сургалт семинарыг зохион байгуулж тус стандарт удирдамж арга зүйн баримт бичгийг танилцуулж, мөн ажлын байранд тавигдах ХАБЭА-н талаарх стандартыг хангах, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага" сэдвээр арга зүйн зөвлөмж, сургалт зохион байгуулсан. Байруудын хурлын заалны захиалгыг цахим хэлбэрээр авч, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хэрэглэгчдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын систем /ERP/-д шинэ цэс үүсгэхээр холбогдох судалгааг хийж, хэрэгжүүлэхэд бэлэн	100%



		болсон ба 2022 онд программчилахаар холбогдох зардалыг төсөвлөж батлуулсан.	
Хэсгийн дундаж хувь:			100%
<b>Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал</b>			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Сул орон тооны 12 удаагийн зарыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, <a href="http://www.unegui.mn">www.unegui.mn</a> цахим хуудас болон нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд нээлттэй зарлан ажилласан.	100%
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Тус газрын ажилтны ёс зүйн дүрмийг цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж ажилласан. <a href="http://khangardi.mn/?page_id=4047">http://khangardi.mn/?page_id=4047</a>	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа дүрэм, журмыг байгууллагын цахим хуудаст тогтмол байршуулан ажилласан. <a href="http://khangardi.mn/?page_id=4047">http://khangardi.mn/?page_id=4047</a>	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын хүний нөөцтэй холбоотой 12 төрлийн мэдээ, мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудас, пэйж хуудас, шилэн дансанд тус тус байршуулсан. <a href="http://khangardi.mn/?page_id=3583">http://khangardi.mn/?page_id=3583</a>	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Ажилтан, албан хаагчдын үр чадварыг холбогдох журмын дагуу улирал бүр дүгнэж, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үр чадварын нэмэгдлийг сар бүр олгон ажилласан ба дүгнэх журам, дүгнэсэн байдлыг цахим хуудаст тухай бүр нь байршуулж ажиллалаа. Мөн ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажлыг байгууллагын Үнэлгээний баг улирал бүр Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан ба энэ талаар мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулж ажилласан. <a href="http://khangardi.mn/?page_id=3613">http://khangardi.mn/?page_id=3613</a>	100%
Хэсгийн дундаж хувь:			100%

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

Нийслэл хотын иргэдийн нийтийн соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор 2020 онд "Нэг хот-Нэг стандарт" зорилтот жилийн хүрээнд "ХОТ СОЁЛТОЙ БОЛ ГОЁ" уриатайгаар "Хотын соёл" аяныг зохион байгуулсан билээ. Тус аянд идэвх санаачилагатай оролцож, хотынхоо хөгжил цэцэглэлтэд байгууллагын зүгээс үйл ажиллагаагаараа дамжуулан хувь нэмрээ оруулан "ШИЛДЭГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ"-аар шалгарлаа.



Зураг 67. "Шилдэг хэрэгжүүлэгч агентлаг"-ийн шагналаа гаргаж авсан

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн "Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/25 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчид 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 14, 15, 16, 17 дугаар хороодын нутаг дэвсгэрийн зах, худалдааны төв, аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, үйлчлүүлж буй иргэдийг QR кодоор бүртгэлжүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа.



Зураг 68. Хяналт шалгалт хийх үеэр

Нийслэлийн Засаг даргын уриалсан "Дэм дэмэндээ 2" аянд манай хамт олон нэгдэж, коронавируст цар тахлын нөлөөллийн улмаас ажлын байр нь түр хаагдсан, орлого нь тасарсан айл өрхүүдэд тусламж үзүүлэх зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 4, 26, 36-р хорооны 80 өрх, байгууллагын өндөр настан 40 өрх, нийт 120 өрхөд өрхөд хүнсний багцын тусламж үзүүллээ.



Зураг 69. Хүнсний багцыг олгох үеэр

Хотын захиргааны цогцолбор байрыг коронавирусын халдвар авсан жирэмсэн эхчүүдийг хүлээн авах түр эмнэлэг болгож, 145 орыг дэлгэх бэлтгэл ажил, цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллаж байна.



Зураг 70. Ор дэлгэх бэлтгэл ажлын үеэр

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан үйл ажиллагааны хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан “Би жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг БАЙНА” уриатай аянд байгууллага, хамт олноороо нэгдэж, жендэрийн тогтсон хэвшмэл буруу ойлголт, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын эсрэг, бүгдээрээ тэгш эрх, тэгш оролцоотой нийгмийг бүтээхийн төлөөх үйлсэд уриалан оролцсон.





Зураг 71. Аянд нэгдсэн байдал

Нийслэлийн засаг захиргааны байруудын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдыг ажиллах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс нийтийн эзэмшлийн гадна талбайд мод, бут, сөөгний үрсэлгээг суулган хаврын цэцэгжүүлэлт, ногоон байгууламж, тохижилтын ажлыг зохион байгууллаа.



Зураг 72. Цэцэгжүүлэлт хийгдсэн байдал

НЗЗ-ны 2-р байрны 1 давхрын ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан стандартад нийцүүлэн тохижуулсан.



Зураг 73. Ариун цэврийн өрөөг тохижуулсан байдал

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ӨГӨӨМӨР ӨДӨР" аяныг 2021 онд "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөөе" уриатайгаар зохион байгууллаа. Тус аянд байгууллагын ажилтан, албан хаагчид идэвх санаачилгатай оролцож, цуглуулсан зүйлсээ Чингэлтэй дүүрэгт хүлээлгэн өглөө.



*Зураг 74. Өгөөмөр өдөр аянд нэгдсэн байдал*



*Зураг 75. Хүндэтгэлийн өргөөнд хөшиг 2 төрөл, хивс, гэрийн бүрээсийг шинэчилсэн байдал*



*Зураг 76. Үндэсний их баяр наадмаар Хүй 7 худаагт хүндэтгэлийн гэр барьж байгаа явцаас*

*Зураг 77. Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний үеэр гэр барьж байгаа явцаас*


Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний аянд нэгдэж, тус газраас 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр 120 гүйлс модыг тарьсан.



*Зураг 78. Мод тарих үйл явцаас*

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг

олон нийтэд ил тод, нээлттэй болгох зорилтын хүрээнд зохион байгуулж буй “Нээлттэй хаалганы өдөрлөг 2021” арга хэмжээнд оролцож, иргэд олон нийтэд байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулж, ажлын байрыг нээлттэйгээр зарлалаа.



Зураг 79. Нээлттэй хаалганы өдөрлөгийн явцаас

Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 382 жилийн ой, нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас нийслэлийн дүүргүүдийн Тамгын газрын цэвэрлэгээ, үйлчилгээ хариуцсан аж ахуйн тасаг, нийтлэг үйлчилгээний алба, ОНӨААТҮГ-ийн удирдлага, албан хаагчдын дунд UCS0202B:2020 "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага" баримт бичгийг сурталчлан таниулах сургалт семинарыг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа.

Тус сургалтад хамрагдсан албан хаагчдад байгууллагын үндсэн чиг үүргийн талаар болон “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS 0202B:2020 стандарт удирдамж арга зүйн баримт бичгийг танилцуулж, мөн ажлын байранд тавигдах ХАБЭА-н талаарх стандартыг хангах, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага” сэдвээр арга зүйн зөвлөмж, сургалт зохион байгууллаа.



Зураг 80. Сургалт, семинарын явцаас

НЗДТГ-ын Сургалт, судалгааны төвөөс нийслэлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, албан хаагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинэ санал,

санаачилгыг нээн илрүүлэх зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 23-ны өдөр нутгийн захиргааны 23 байгууллагын 21 багийн албан хаагчдын дунд зохион нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын мэтгэлцээний анхдугаар тэмцээн байгуулсан. Тус мэтгэлцээнд хамт олноо төлөөлөн орлогч дарга Б.Галмандах, дотоод ажил, сургалт хариуцсан ажилтан Ц.Үрэлмаа, байр хариуцсан менежер Х.Долгормаа нар оролцсон.



Зураг 81. Мэтгэлцээний явцаас

Мөн байгууллагын 25 жилийн ойг угтаж ажилтан, албан хаагчдыг уриалсан, манлайлсан арга хэмжээнүүдийг дараах байдлаар зохион байгуулсан. Тухайлбал:



Зураг 82. Төрийн албан хаагчдыг хүндэтгэлтэйгээр угтан авч буй явцаас

Захиргаа, санхүүгийн хэлтсээс 2021 оны 10 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд “Өөрчлөлтийг өнөөдрөөс өөрөөсөө” аян



Зураг 83. “Өөрчлөлтийг өнөөдрөөс өөрөөсөө” аяны явцаас

Үйлчилгээний албанаас 2021 оны 11 дүгээр сарын 01-08-ны өдрүүдэд “Талархлын өдрүүд” аян



Зураг 84. “Талархлын өдрүүд” аяны явцаас

Байр ашиглалтын албанаас 2021 оны 11 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд “Эрүүл, аюулгүй ажлын байр” аян



Зураг 85. “Эрүүл, аюулгүй ажлын байр” аяны явцаас

Захиргаа, санхүүгийн хэлтсээс 2021 оны 11 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” аян



Зураг 86. “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” аяны явцаас

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” аяны хүрээнд Нийслэлийн цагдаагийн удирдах газартай хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ” сэдэвт сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр, “Сайхан харилцаа, тайван амьдрал” сэдэвт сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр тус тус зохион байгуулсан.



Зураг 87. Сургалтын үеэр



Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын, авлагагүй, цусны донорын эгнээг өргөжүүлэх, цусны донорын үйлсийг сурталчлах, тэднийг алдаршуулж урамшуулах зорилго бүхий Сар бүрийн 3-ны “Цусаа бэлэглэх өдөр”-ийн 81 дэх удаагийн арга хэмжээг тохиолдуулан Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран “Цусаа бэлэглэе” сайн үйлсийн аяныг 2021 оны 12-р сарын 03-ны өдөр НЗДТГ-ын спорт заал, НҮНТ-ийн Дүнжингарав салбарт тус тус амжилттай зохион байгуулж эхлүүлсэн. Тус арга хэмжээг хуваарийн дагуу 4 удаа зохион байгуулж НЗДТГ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нийт 200 гаруй төрийн албан хаагч хамрагдаж 600 хүнд амьдрал бэлэглэх их үйлсэд нэгдсэн.



Зураг 88. Цусаа бэлэглэе аяны үеэр

Худалдаа, хоршоо, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг угтан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын Мастер тогоочдын холбоо, Монголын ахлах тогоочийн академитай хамтран 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Хотын аварга тогооч” шалгаруулах ажил мэргэжлийн уралдаанд нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ерөнхий тогооч Э.Гал-Эрдэнэ амжилттай оролцож “ДЭД БАЙР”-т шалгарлаа.



Зураг 89. Хотын аварга тогооч уралдааны үеэр

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр байгууллагын 18-34 насны 40 гаруй ажилтан, албан хаагчдад “Маргааш хөтлөх хүч” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



Зураг 90. Залуучуудын сургалтын үеэр

Байгууллагын 2021 оны тайлангийн хурлын үеэр хэлтэс албадууд энэ онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа амжилттай тайлагналаа. Хурлын үеэр хамт олноо манлайлан ажил үйлсээрээ тэргүүлэн ажилласан дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтан Т.Итгэл, байр хариуцсан менежер М.Алтантуяа, тогооч Ч.Пүрэвжав нар 2021 оны байгууллагын “ШИЛДЭГ АЖИЛТАН”-аар, захиргаа, мөн нярав Г.Мөнхцэцэг, цахилгаанчин С.Алтаншагай, үйлчлэгч М.Оюунгэрэл нар “ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА”-аар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.



*Зураг 93. Тайлангийн хурлын үеэр*

Хөдөлмөр бүтээлээрээ бусдыгаа манлайлж, идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэдийг алдаршуулах зорилгоор нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо хамтран нийслэлийн “Хөдөлмөрийн аварга”-уудыг тодруулдаг уламжлалтай.

Нийслэлийн 2021 оны “Хөдөлмөрийн аварга”-аар нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын цахилгааны инженер Батболдын Батсүрэн шалгарч, нийслэл хотынхоо хөгжил бүтээлд оруулсан хувь нэмрээ үнэлүүллээ.



*Зураг 93. Нийслэлийн хөдөлмөрийн аварга ажилтан болсон шагнал гардуулах үеэр*

## ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 оны хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд нутгийн захиргааны байгууллага болон төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, үр дүнг тооцож ажилласан.

Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, төсөв санхүүгийн сахилга батыг ханган ажиллалаа.

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудал, сурч боловсрох, тэдний ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад анхааран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаагаа бүрэн хангалттай хэрэгжүүлж ажилласан.

Манай байгууллага нь тайлант хугацаанд дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, цаг үеийн шинж чанартай дээд газраас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай хамрагдан, өгөгдсөн үүрэг чиглэлийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

ТАНИЛЦСАН:  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:  
ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ  
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ц.ҮРЭЛМАА

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7
<b>ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ</b>						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	24	Тайлант хугацаанд 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 525 ажилтан, албан хаагч хамрагдсан. Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 59 удаагийн сургалтад давхардсан тоогоор 797 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан.	100%
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	1.1.1. Баримт бичиг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөх ур чадварыг сайжруулах сургалт	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс 10 удаагийн сертификаттай сургалтад давхардсан тоогоор 92 албан хаагчийг хамруулсан. Тухайлбал:	100%
					<ol style="list-style-type: none"> <li>1. “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй” сэдэвт сургалтад 1;</li> <li>2. “Төрийн архивын баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх, нөхөн бүрдүүлэлтээр баримт хүлээн авах, данс, бүртгэл үйлдэх арга зүйн” сургалтад 1;</li> <li>3. “Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй” сургалтад 1;</li> <li>4. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх сургалтад 1;</li> <li>5. “Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт сургалтад 1;</li> <li>6. “Зөв менежмент- Зөв тогтолцоо” стандарт танилцуулах сургалтад 24;</li> <li>7. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, түүнийг тайлагнах, үнэлэхтэй холбоотой 4 модульд сургалтад 45;</li> <li>8. Цагийн менежмент сургалтад 2;</li> <li>9. “Төслийн удирдлагын үндэс” сургалтад 7;</li> <li>10. Алсын хараа 2050 богино хугацааны сургалтад 9 албан хаагч тус тус хамрагдаж сертификат гардан авсан.</li> </ol>	
Тайлант онд ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх 20 удаагийн сургалтад давхардсан тоогоор 612 албан хаагч хамрагдсан. Мөн ёс зүйн дүрмийг байгууллагын мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан ажилтан, албан хаагчдад сурталчлан ажилласан. Үүнд: Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2021 оны 03/4229 дүгээр чиглэл						

1	2	3	4	5	6	7
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс		<p>1.1.2. Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх</p>	<p>хүргүүлэх тухай албан бичгийн хүрээнд байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын тогтвор суурьшил, ар гэрийн тайван байх нөхцөлийг бүрдүүлэх, өртөж болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, журмын мэдлэгийг дээшлүүлэх, бусдыг уриалах зорилгоор "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аяныг 2021 онд 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 03-ны хугацаанд зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ" сэдэвт сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Нийслэлийн цагдаагийн удирдах газрын урьдчилан сэргийлэх хэлтсийн мэргэжилтэн, ахмад н.Уранбат гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх холбогдох хууль, тогтоомжийг тайлбарлаж эрх зүйн мэдлэгийг 147 ажилтан, албан хаагчдад олголоо.</li> <li>- Ажилтан, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хөгжөөнт АХА тэмцээнийг зохион байгуулж байр тус бүрээс нийт 20 ялагчийг тодруулж, эцсийн шатны шалгаруулалт 2 албан хаагч шалгаруулж, урамшууллаа. Тус тэмцээнд байгууллагын 217 ажилтан, албан хаагч хамрагдсан.</li> <li>- Цагдаагийн ерөнхий газраас гаргаж буй өдөр тутмын мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлгийг цаг алдалгүй хүлээн авах зорилгоор ажилтан, албан хаагчид Цагдаагийн ерөнхий газрын пэйж хуудаст фоллов хийж уриалгыг гаргасан ба ажилтан албан хаагчид идэвхтэй хамрагдлаа.</li> <li>- Ажилтан, албан хаагчдыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Сайхан харилцаа, тайван амьдрал" сэдэвт сургалтад байгууллагын 147 ажилтан, албан хаагч хамруулж тус тус ажиллалаа.</li> </ul>	100%
				<p>1.1.3. Монгол бичиг, монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүйн тухай ойлголт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах</p>	<p>Тайлант хугацаанд Нийслэлийн сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан "Монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүй" сургалтад 32 албан хаагч хамрагдсан.</p> <p>Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын монгол бичгийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор монгол бичгийн анхан шатны сургалтыг "Монгол бичгээ сурцгаая" уриатайгаар видео хэлбэрээр 3, танхимаар 7 удаа нийт 130 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Төрийн албан хэргийг 2025 оноос кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын монгол бичгийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор монгол бичгийн анхан шатны сургалтыг "Монгол бичгээ сурцгаая"</p>	100%

1	2	3	4	5	6	7
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс			уриатайгаар видео хэлбэрээр бэлтгэж, байгууллагын группэд байршуулсан.	
				1.1.4. Судалгааны арга зүй, дотоод хяналтыг сайжруулах чиглэлийн сургалтанд хамруулах	Дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 4 удаагийн сургалтад ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан. Үүнд: 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлал, загварыг танилцуулах сургалтад 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр 45; 2. Төрийн албаны зөвлөлөөс 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан “Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл” сургалт 45; 3. НӨАУГ-аас 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Нийслэлийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөнийг зохицуулах журам, тогтоол шийдвэрийн хэрэгжилт төрийн байгууллагуудын өмчийн харилцаа ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, өдөр тутамд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх талаар зөвлөгөө, сургалтад 18; 4. Төрийн албаны зөвлөлөөс 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан “Албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтад 1 албан хаагчид тус тус хамрагдсан.	100%
				1.1.5. Шинээр томилогдон ажилтан, албан хаагчдад ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг таниулах, ажлын байранд сургах сургалт зохион байгуулах	Шинээр томилогдсон болон үйлчилгээний ажилтнуудад “Цэвэрлэгээ үйлчилгээний тавигдах ерөнхий шаардлага стандарт, харилцаа хандлага, ёс зүйн” сургалтыг бүлгээр болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж ажиллалаа.	100%
				Тайлант хугацаанд хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шинэчлэлтэй холбоотой сургалтад захиргааны 46 албан хаагчдыг хамруулсан. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хууль, эрх зүйн хэлтсээс 2021 оны 09 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга”, “Нийслэлийн эрх	100%	

1	2	3	4	5	6	7
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс		1.1.6. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шинэчлэл, стандартын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах	зүйн мэдээллийн нэгдсэн сан ublegal.mn сайтыг танилцуулга” арга зүйн цахим сургалтад; 1. Төрийн албаны зөвлөл 2021 оны 09 дугаар сарын 14-ний өдөр “Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, (шинэчилсэн найруулга)-ын зорилт, зохицуулах харилцаа” арга зүйн цахим сургалтад 46; 2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр сургалт. Тайлант хугацаанд манай байгууллагын санаачлан боловсруулж батлуулсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS 0202B:2020 стандарт удирдамж арга зүйн баримт бичгийг нийслэлийн 9-н дүүргийн Тамгын газрын цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгж, тасгийн ажилтан, албан хаагчдад таниулах сургалт семинарыг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулж ажиллалаа.	
				1.1.7. Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын мэргэшил дээшлүүлэх сургалтад сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэх	Байгууллагын хэмжээнд Хүмүүнлэгийн Ухааны их сургуульд хэл шинжлэлийн магистрантурт 1, Удирдлагын академид төрийн удирдлагын магистрантурт 2, Олон улсын Улаанбаатар их сургуульд эрх зүйн магистрантурт 1, МУИС-д хүний нөөцийн ажилтнаар магистрантурт 1, Санхүү, эдийн засгийн их сургуульд бизнесийн удирдлагаар магистрантурт 1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын дээд сургуулийн ХАБЭА бакалаврт 1, ХААИС-ийн газар зохион байгуулалтын бакалаврт нийт 8 албан хаагч хувийн зардлаараа суралцаж байна.	100%
				1.1.8. Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 стандарт нэвтрүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Тайлант хугацаанд: - Монголын стандарт, чанарын хүрээлэнгээс 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 30-ны өдрүүдэд “Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт цахим сертификаттай сургалтад 1; - “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн” цахим сургалт 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 6 албан хаагч; - 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Засгийн газрын байруудын үйлчилгээний албаны дарга н.Эрдэнэбаярын “Чанарын өдөрлөг” сургалтад 1 албан хаагчид тус тус хамрагдсан.	100%
					Тайлант хугацаанд коронавируст (ковид-19) цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд: МҮЭХ-ны Залуучуудын хорооноос 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр	

1	2	3	4	5	6	7
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт дотоод	Үүнээс	Бусад	1.1.9.Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх сургалтуудад ажилтан, албан хаагчдыг хамруулах	<p>зохион байгуулсан "Хөдөлмөрийн эрүүл ахуй ба ковид-19" сургалтад албан хаагч - 20;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Коронавируст /Ковид-19/ халдварын өвчлөл буурахгүй байгаатай холбоотойгоор их эмч Н.Энхзаяа 2021 оны 05 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд албан хаагчдад Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 7-ны тушаалаар коронавируст халдварын эсрэг вакцины дархлаажуулалтад нэмэлт зохицуулалт оруулсан талаарх мэдээлэл болон "Коронавирус /Ковид-19/-ээс урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнөөр дархлаа сайжруулах" чиглэлээр зөвлөгөөг хүргэх сургалтад албан хаагч- 45;</li> <li>- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-тай хамтран 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх" сэдэвт сургалтад ажилтан, албан хаагч – 50;</li> </ul>	
			Туршлага солилцох арга хэмжээ	1.2.1. Удирдах албан тушаалтануудыг төрийн албаны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулах	НЗДТГ-аас 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан "Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийн хэлтсийн дарга нарт зориулсан багц сургалт"-д 3 албан хаагч хамрагдсан.	100%
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	281	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 26 арга хэмжээ төлөвлөснөөс 24 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, давхардсан тоогоор 525 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 92.3%-ийн биелэлттэй байна. Өнгөрсөн оны мөн үеэс өссөн байгаа нь цахим сургалтад хамруулсантай холбоотой байна. Дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 59 удаагийн сургалтад давхардсан тоогоор 797 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулж ажиллалаа.	100%
			Эмэгтэй албан хаагч	185	185	100%
	Эрэгтэй албан хаагч	96	96	100%		



1	2	3	4	5	6	7
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	Үүнээс	Удирдах албан тушаалтан	6	6	100%
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	275	275 гүйцэтгэх, туслах албан тушаалтан	100%
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021 онд 10 удаагийн сертификаттай сургалтад давхардсан тоогоор 92 албан хаагчийг хамруулсан. Тухайлбал: 1. "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй" сэдэвт сургалтаар албан хаагч 1; 2. "Төрийн архивын баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх, нөхөн бүрдүүлэлтээр баримт хүлээн авах, данс, бүртгэл үйлдэх арга зүйн" сургалтаар албан хаагч 1; 3. "Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сургалтаар албан хаагч 1; 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх сургалтаар албан хаагч -1; 5. "Чанарын менежментийн шинэ хандлага" сэдэвт сургалтаар албан хаагч -1; 6. "Зөв менежмент- Зөв тогтолцоо" стандарт танилцуулах сургалтаар албан хаагч - 24; 7. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, түүнийг тайлагнах, үнэлэхтэй холбоотой 4 модульт сургалтаар албан хаагч – 45; 8. Цагийн менежмент сургалтаар албан хаагч – 2; 9. "Төслийн удирдлагын үндэс" сургалтаар албан хаагч – 7; 10. Алсын хараа 2050 богино хугацааны сургалтаар 9 албан хаагч тус тус хамрагдаж сертификат гардан авсан.	100%
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо			-
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо			-
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч			-
			Эрэгтэй албан хаагч			-
			Удидах албан тушаалтан			-
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан			-
2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал:			-		

1	2	3	4	5	6	7
			Нийт албан хаагчдад эзлэх хувь		20-оос дээш	-
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	100%	Тайлант хугацаанд албан хаагчдыг ажил үүргийн холбогдох чиглэлийн дагуу 7 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад 2.800.000 төгрөгийг зарцуулсан байна.	100%
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн нь 0.034 хувийг эзлэж байна.	100%
<b>АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ</b>						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	Төсөвт эзлэх хувь 2.2 %	Тайлант хугацаанд: <ul style="list-style-type: none"> <li>- Ажилтан албан хаагчдын ажлыг улирлаар дүгнэн давхардан тоогоор 275 ажилтан, албан хаагчдад 225.714.062 төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 212.415.424 төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.</li> <li>- Илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу 275 ажилтан, албан хаагчид нийт 210.299.849 төгрөгний нэмэгдэл хөлсийг тухай бүр олгож ажилласан.</li> <li>- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын дагуу 212.415.424 төгрөгийг ажилтан, албан хаагчийг төрийн албанд ажилласан жилийн судалгааг гарган төрийн байгууллагад ажилласан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгон ажиллаж байна.</li> <li>- Эрхэлсэн ажилдаа тогтвор суурьшилтай, ажилдаа амжилт гаргасан ажилтан албан хаагчдыг судлан төрийн болон яам, НИТХ, НЗД-ын шагналын журмын дагуу тодорхойлон холбогдох дээд байгууллагуудад материалыг хүргүүлж шагнаж урамшуулсан байна. Үүнд: Төрийн дээд одон медалиар 3, МУ-ын Засгийн газар, яамдын шагналаар 24, ТЗҮЭГазрын шагналаар 2, НИТХ-ын шагналаар 26, НЗД-ын шагналаар 19 нийт 74 ажилтан, албан хаагч шагнагдсан.</li> </ul>	100%

1	2	3	4	5	6	7
		4.2.	Нэгж албан хаагчид олгох, хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	Ажилтан, албан хаагчдад хоол, унааны зардлын зохих хэсгийг олгох	Ажилтан, албан хаагчдад 2021 онд 131.063.500 төгрөгийг унаа, хоолны зардалд олгосон байна.	100%
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг 2021 оны 08 дугаар сард цахим болон цаасан хэлбэрээр зохион байгууллаа. Судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 65% нь сайн үнэлгээ өгсөн ба төрийн албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтийг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах үүргийг холбогдох албан хаагчид өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.	100%
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд)	1-ээс дээш	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд "Оюу шүр мед" эмнэлэгтэй хамтран 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөс 12-ны өдрүүдэд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 250 ажилтан, албан хаагчийг хамруулсан.	90%
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	ЧДЭМТ-ийн нян судлалын лабораторитой хамтран 2021 оны 2, 10 дугаар сард зоогийн газрын тогооч, зөөгч, бэлтгэгч, угаагч 29 ажилтныг 2 удаа эрүүл мэндийн шинжилгээнд хамрууллаа.	
7	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр	Тайлант хугацаанд: Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 34 ажилтан, албан хаагчдад 8,176,566 төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж, өндөр насны тэтгэвэрт гарч буй 3 ажилтанд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолыг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн буцалтгүй тусламж 44,508,131 төгрөгийг олгосон. Нийт 52,684,697 төгрөгийг зарцуулсан байна.	100%

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Ч.ШИНЭЧИМЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

 Н.БУЛГАНЧИМЭГ